**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

БУЛГАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**Аудитын код: БУА-2026/001/НА-СТА-ТЕЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2026 он | Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт<br>Утас: 70342716 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn<br>Аудитын менежер:Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Г.Намчинсүрэн<br>Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 21 өдөр  Дугаар А/11  Булган сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаал батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам” -ын 3.1, “Эрх шилжүүлэх тухай” 2025 оны А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, алдаа, зөрчлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Намчинсүрэн), (П.Мөнхтуяа) нарт үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Д.Пүрэв-Очир), аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд) нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (Г.Намчинсүрэн), (П.Мөнхтуяа) нарт тус тус даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Булган аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Г.Намчинсүрэн), (П.Мөнхтуяа) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ

6326010022

## АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 4

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** 7

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 15

**3.4.1 Мөнгөн хөрөнгө** ..... 18

**3.4.2 Авлага** ..... 19

**3.4.3 Урьдчилгаа** ..... 21

**3.4.4 Бараа материал** ..... 21

**3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө** ..... 23

**3.4.6 Үндсэн хөрөнгө** ..... 23

**3.5.7 Өр төлбөр** ..... 25

**3.4.8 Засгийн газрын хувь оролцоо** ..... 27

**4.1 Ерөнхий зүйл** ..... 27

**4.2 Материаллаг байдал** ..... 28

**4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 28

**4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 29

**4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 29

**4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 31

**4.7.1 Завсрын аудитын талаар** ..... 31

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 31

**5.2.1 Зөвлөмж** ..... 32

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 35

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| НББТХ | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт |
| ТЕЗ | Төсвийн Ерөнхийлөн захирагч |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ШШГА | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| БХС | Байгаль хамгаалах сан |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.04.21 № 390

танай ___ ны № ___ т

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР
ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчилтэй асуудал нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах үндэслэлээр хязгаарлалттай дүгнэлт өгч байна. Үүнд:

- Сангийн сайдын 2025 оын 03 дугаар тогтоолоор "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинэчлэгдсэн, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд нь гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн баталсан НБББББ-ийг шинэчлэх шаардлагатай байна,
- Сумдын жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас зээл олгохдоо эрх зүйн үндэслэл, журамгүйгээр багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн олгож байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна,
- Зарим сумын Ерөнхий орлогын дансанд ээн холбогдогч нь тодорхойгүй 5 жилээс дээш насжилттай нийт 93.6 сая төгрөгийн авлага тайлагнагдсаар байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын ангилал, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна,

6320050637

- Татан буугдсан аймгийн Нөөцийн газарт 0.02 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн, 93.2 сая төгрөгийн бараа материал, 42.4 сая төгрөгийн авлага, 18.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 162.7 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй байна,
- Жаргалант хүүхдийн зуслангийн 28.9 сая төгрөгийн бараа материал, 1,628.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна,
- "Булган сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт зарцуулагдах төсвийг төлөвлөхдөө холбогдох хөтөлбөр (дэд), жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байхад аймгийн Засаг даргын захирамжаар шаардагдах төсвийг хавсралтаар баталж, зарцуулсан байна,
- Аймгийн Засаг дарга, Орхон аймгийн "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хооронд байгуулсан гэрээний заалтад заасан "Уул, уурхайг ашиглах, хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалахтай холбогдуулан шинээр ажлын байр бий болгох гарааны бизнес, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх" гэсэн заалтад хамааралгүй, төлөвлөгөөнд тусгагдаж батлуулаагүй "Айраг фиствиаль" төсөл арга хэмжээнд 100.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдсэн "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд ойн зурвас, байгуулах, төсөл арга хэмжээний ажлын гэрээнд тарьсан модны 75 хувьд хүрээгүй бол нөхөн тарилтыг бортоготой тарилтаар тарина гэсэн заалтын дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлж 75 хувьд хүрсэн эсэхийг үнэлж, дүгнэсэн мэргэжлийн байгууллагын тайлан байхгүй, баримтжуулж ажиллаагүй байна,
- Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлаас бөхийн барилдааны тасалбарын зардалд 0.5 сая төгрөг зарцуулсан,
- Аймгийн Засаг даргын 2025 оны А/678 тоот захирамжуудаар "Гадаад албан томилолтоор ажиллуулах тухай" шийдвэрийн хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-Хөх хотод нийт 5 хүний зардалд 16.4 сая төгрөг зарцуулж, "Төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн зардлаас санхүүжүүлсэн. Тухайн 5 хүний 2 нь аймгийн ИТХ-ын төлөөлөгч бөгөөд төрийн албан хаагч биш байхад 5.4 сая төгрөгийг зарцуулсан нь хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулгатай нийцэхгүй байна,
- "Төрийн албаны сэргэлт болон цахим ур чадвар олгох сургалт"-ын зардлаас хоолны зардалд 0.9 сая төгрөгийг зарцуулсан,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 24,133.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн, "Тохижилт үйлчилгээний анги"-ийн 2,621.4 сая төгрөгийн хөрөнгийн дүн санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажаагүй, нийт 26,754.5 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.1, 20.2.2, 20.2.8, 20.2.9, 20.2.10, Төсвийн тухай хуулийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, 78.1, Төсвийн тухай хуулийн 6.4.8, 14.2.10, 37.1.1, 37.1.5, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3 дугаар зүйлийн 3.9.7, санхүүгийн тайлангийн аудитын ангилал, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2025 оны 8 дугаар сарын 22-ны өдөр аймгийн ИТХ-ын 10/74 дугаар тогтоолоор аймгийн төсвийн нийт татварын орлогыг 66,342.0 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 68,118.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

**Бусад хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аймгийн ИТХ-ын 2025 оны XIII/89 дугаар тогтоолоор "Булган аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийг 82.2 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

*/мянган төгрөгөөр/*

| № | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | 1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 47,588,216.07 | 45,265,253.8 |
| 2 | 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 32,323,926.94 | 29,881,100.06 |
| 3 | 1.1.3 АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 7,973,483.71 | 8,277,579.57 |
| 4 | 1.1.4 УРЬДЧИЛГАА | 7а, 7б | 6,817 | 38,992.22 |
| 5 | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 6,617,857.73 | 6,881,097.83 |
| 6 | 1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 10 | 666,130.7 | 186,484.12 |
| 7 | 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 111,817,557.5 | 120,934,614.29 |
| 8 | 1.2.1 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 11а, 11б | 213,012.87 | 59,546.65 |
| 9 | 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 111,604,544.64 | 120,875,067.64 |
| 10 | 1.2.2.02 Биет хөрөнгө | | 101,000,109.53 | 110,057,216.37 |
| 11 | 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 13 | 10,604,327.11 | 10,817,743.26 |
| 12 | 1.2.2.04 Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 14 | 108 | 108 |
| 13 | 1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | | 159,405,773.58 | 166,199,868.09 |
| 14 | 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 22,145,372.25 | 23,607,342.37 |
| 15 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 8,865,111.92 | 10,751,504.14 |
| 16 | 2.1.1.03 Өглөг | | 8,862,531.92 | 10,737,690.22 |
| 17 | 2.1.1.04 Урьдчилж орсон орлого | 18а, 18б | 2,580 | 13,813.92 |
| 18 | 2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 13,280,260.33 | 12,855,838.23 |
| 19 | 2.1.2.02 Урт хугацаат зээл | 20а, 20б | 13,280,260.33 | 12,855,838.23 |
| 20 | 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 137,260,401.33 | 142,592,525.72 |
| 21 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | | 137,260,401.33 | 142,592,525.72 |
| 22 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | | 38,616,863.08 | 38,610,931.23 |
| 23 | 2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | 2,562,851.4 | 2,568,783.25 |
| 24 | 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | | 85,995,709.21 | 91,273,112.5 |
| 25 | 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 10,084,977.64 | 10,139,698.74 |
| 26 | 2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | | 159,405,773.58 | 166,199,868.09 |

## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

*/мянган төгрөгөөр/*

| № | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | | 118,507,437.45 | 107,517,019.76 |
| 2 | 1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | | 61,540,415.06 | 68,109,973.3 |
| 3 | 1.1.1.03.1 Орлогын албан татвар | | 20,401,501.13 | 22,502,211.52 |
| 4 | 1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар | | 20,278,515.42 | 21,712,879.24 |
| 5 | 1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | -817,084.3 | -1,149,154.23 |
| 6 | 1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар | | 940,070.01 | 1,938,486.51 |
| 7 | 1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | | 6,845,633.18 | 11,214,343.31 |
| 8 | 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | | 34,293,280.76 | 34,393,418.47 |
| 9 | 1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 52,654,715 | 39,407,046.47 |
| 10 | 1.1.1.04.2 Хөрөнгийн орлого | | 88,902.15 | 119,463.39 |
| 11 | 1.1.1.04.3 Тусламжийн орлого | | 0.0 | 3,634,362.44 |
| 12 | 1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 4,312,307.38 | 0.0 |
| 13 | 1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 82,011,809.98 | 87,559,662.6 |
| 14 | 1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | | 82,011,809.98 | 87,306,464.5 |
| 15 | 1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 72,179,298.39 | 79,389,851.64 |
| 16 | 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 20,089,924.28 | 23,646,275.44 |
| 17 | 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 2,516,792.78 | 3,469,647.63 |
| 18 | 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 12,899,985.27 | 17,211,162.27 |
| 19 | 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | | 2,015,099.34 | 2,008,633.04 |
| 20 | 1.1.2.01.1.05 Нормативт зардал | | 347,030.39 | 496,317.49 |
| 21 | 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | | 1,290,066.06 | 2,038,216.24 |
| 22 | 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | | 557,399.99 | 577,638.32 |
| 23 | 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 6,785,904.6 | 6,380,938.44 |
| 24 | 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | | 25,677,095.68 | 23,561,022.78 |
| 25 | 1.1.2.01.2 ХҮҮ | | 2,261,856.1 | 1,328,161.9 |
| 26 | 1.1.2.01.3 ТАТААС | | 412,000 | 370,367.4 |
| 27 | 1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 7,158,655.49 | 6,218,083.55 |
| 28 | 1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 0.0 | 253,198.11 |
| 29 | 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 36,495,627.47 | 19,957,357.16 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 30 | 1.2.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | 1,900 | 4,227.66 |
| 31 | 1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 16,338,953.02 | 15,561,129.23 |
| 32 | 1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | | -16,337,053.02 | -15,556,901.56 |
| 33 | 1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | | 20,158,574.45 | 4,400,455.6 |
| 34 | 2 Засгийн газрын хувь оролцоо | | 0.0 | 547,718.2 |
| 35 | 3 Хяналтын бус хувь оролцоо | | 0.0 | 547,718.2 |

## НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

*/мянган төгрөгөөр/*

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 115,316,441.04 | | 115,316,441.04 |
| 2 | 1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 133,178.22 | | 133,178.22 |
| 3 | 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 115,449,619.26 | | 115,449,619.26 |
| 4 | 1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 7,643.62 | | 7,643.62 |
| 5 | 1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 1,464,834.43 | | 1,464,834.43 |
| 6 | 1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт | 179,729.57 | | 179,729.57 |
| 7 | 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 20,158,574.45 | | 20,158,574.45 |
| 8 | 1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 137,260,401.33 | | 137,260,401.33 |
| 9 | 1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 137,260,401.33 | | 137,260,401.33 |
| 10 | 1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 873,764.16 | | 873,764.16 |
| 11 | 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 138,134,165.49 | | 138,134,165.49 |
| 12 | 1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 54,721.1 | | 54,721.1 |
| 13 | 1.5 Өмчид гарсан өөрчлөлт | 3,183.54 | | 3,183.54 |
| 14 | 1.7 Тайлант үеийн үр дүн | 4,400,455.6 | | 4,400,455.6 |
| 15 | 1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 142,592,525.72 | | 142,592,525.72 |

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

*/мянган төгрөгөөр/*

| № | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | 3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 84,578,601.3 | 85,532,358.35 |
| 2 | 3.1.01.1.1 Татварын орлого | 66,342,662.2 | 68,118,595.29 |
| 3 | 3.1.01.1.1.1 Орлогын албан татвар | 22,194,039.2 | 22,502,211.52 |
| 4 | 3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар | 21,374,039.2 | 21,712,879.24 |
| 5 | 3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 17,316,702.3 | 17,681,149.82 |
| 6 | 3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого | 888,762.7 | 952,690.2 |
| 7 | 3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого | 2,984,974.2 | 2,834,857.5 |
| 8 | 3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого | 183,600 | 244,181.72 |
| 9 | 3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -1,150,000 | -1,149,154.23 |
| 10 | 3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -1,150,000 | -1,149,154.23 |
| 11 | 3.1.01.1.1.1.4 ААН-ын орлогын албан татвар | 1,970,000 | 1,938,486.51 |
| 12 | 3.1.01.1.1.1.4.01 ААН-ын орлогын албан татвар | 1,970,000 | 1,938,486.51 |
| 13 | 3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар | 9,086,383.6 | 11,214,343.31 |
| 14 | 3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 6,803,513.4 | 9,005,307.02 |
| 15 | 3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар | 75,688 | 59,403.1 |
| 16 | 3.1.01.1.1.3.3 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 614,900.2 | 618,746.59 |
| 17 | 3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар | 1,592,282 | 1,530,886.6 |
| 18 | 3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 35,062,239.4 | 34,402,040.46 |
| 19 | 3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 735,020.3 | 568,838.22 |
| 20 | 3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж | 245,020.3 | 253,088.96 |
| 21 | 3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 91,000 | 52,761.64 |
| 22 | 3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 399,000 | 262,987.63 |
| 23 | 3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр | 2,595,054.6 | 2,042,721.62 |
| 24 | 3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр | 1,795,054.6 | 1,815,571.07 |
| 25 | 3.1.01.1.1.8.2.02 Дуудлага худалдаа | 800,000 | 227,150.55 |
| 26 | 3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 31,597,164.5 | 31,621,226.81 |
| 27 | 3.1.01.1.1.8.3.01 Ойн нөөц ашигласны төлбөр | 517,000 | 481,424.94 |
| 28 | 3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 50,000 | 42,856.85 |
| 29 | 3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 31,026,200 | 30,733,449.24 |
| 30 | 3.1.01.1.1.8.3.04 Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр | 3,964.5 | 363,495.78 |

| | | | |
|---|---|---|---|
| 31 | 3.1.01.1.1.8.4 Бусад татвар | 135,000 | 169,253.81 |
| 32 | 3.1.01.1.1.8.4.01 Бусад татвар | 135,000 | 169,253.81 |
| 33 | 3.1.01.1.2 Татварын бус орлого | 18,235,939.1 | 17,413,763.07 |
| 34 | 3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого | 7,041,176.8 | 6,326,582.68 |
| 35 | 3.1.01.1.2.1.2 Хүүгийн орлого | 507,311.9 | 0.0 |
| 36 | 3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого | 2,952,500 | 3,531,202.83 |
| 37 | 3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 3,107,803.8 | 2,421,152.53 |
| 38 | 3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 56,761.1 | 15,273 |
| 39 | 3.1.01.1.2.1.6 Түрээсийн орлого | 52,800 | 51,478.71 |
| 40 | 3.1.01.1.2.1.9 Бусад орлого | 364,000 | 307,475.61 |
| 41 | 3.1.01.1.2.2 Хөрөнгийн орлого | 115,000 | 119,463.39 |
| 42 | 3.1.01.1.2.2.1 Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 115,000 | 119,463.39 |
| 43 | 3.1.01.1.2.3 Тусламжийн орлого | -0.1 | 0 |
| 44 | 3.1.01.1.2.3.4 Сум дүүргээс авсан тэгшитгэл | -0.1 | 0 |
| 45 | 3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 11,079,762.4 | 10,967,717 |
| 46 | 3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 11,079,762.4 | 10,967,717 |
| 47 | 3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 105,410,429.6 | 89,671,294.96 |
| 48 | 3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 72,439,695.3 | 67,041,140.51 |
| 49 | 3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 68,577,765.6 | 63,717,048.17 |
| 50 | 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 23,629,772.9 | 22,471,864.84 |
| 51 | 3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин | 11,521,607.6 | 11,268,203.72 |
| 52 | 3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл | 9,640,865.5 | 9,072,109.54 |
| 53 | 3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт | 527,431.2 | 486,424.89 |
| 54 | 3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал | 1,901,953.1 | 1,614,465 |
| 55 | 3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс | 37,915.5 | 30,661.69 |
| 56 | 3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,960,009.5 | 2,789,525.11 |
| 57 | 3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал | 2,008,989.8 | 1,900,624.69 |
| 58 | 3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал | 236,414.8 | 225,958.81 |
| 59 | 3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал | 122,517.3 | 121,431.01 |
| 60 | 3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал | 118,207.3 | 108,460.37 |
| 61 | 3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал | 473,880.3 | 433,050.23 |
| 62 | 3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,780,175.8 | 17,064,243.32 |
| 63 | 3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан | 1,860,817.6 | 1,622,807.87 |
| 64 | 3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт | 15,008,665.2 | 14,619,210.2 |
| 65 | 3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус | 739,854 | 651,386.25 |

| | | | |
|---|---|---|---|
| 66 | 3.1.01.2.1.1.3.04 Байрны түрээс | 170,839 | 170,839 |
| 67 | 3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 1,101,165.2 | 893,490.95 |
| 68 | 3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг | 156,471 | 117,265.15 |
| 69 | 3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун | 544,067.6 | 469,683.86 |
| 70 | 3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 104,850.2 | 90,370.24 |
| 71 | 3.1.01.2.1.1.4.04 Ном, хэвлэл | 1,680 | 615.5 |
| 72 | 3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 213,569.6 | 150,103.89 |
| 73 | 3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 80,526.8 | 65,452.31 |
| 74 | 3.1.01.2.1.1.5 Нормативт зардал | 469,462.2 | 424,310.73 |
| 75 | 3.1.01.2.1.1.5.01 Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 371,562.7 | 370,904.4 |
| 76 | 3.1.01.2.1.1.5.02 Хоол, хүнс | 20,700 | 11,631.43 |
| 77 | 3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл | 77,199.5 | 41,774.9 |
| 78 | 3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 3,011,860.1 | 2,636,169.38 |
| 79 | 3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл | 592,952 | 476,363.45 |
| 80 | 3.1.01.2.1.1.6.02 Тавилга | 174,160.5 | 135,291.75 |
| 81 | 3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 71,000 | 58,984.55 |
| 82 | 3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар | 2,173,747.6 | 1,965,529.64 |
| 83 | 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 611,216.2 | 505,878.06 |
| 84 | 3.1.01.2.1.1.7.01 Гадаад албан томилолт | 238,621.2 | 221,011.59 |
| 85 | 3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт | 350,595 | 268,635.62 |
| 86 | 3.1.01.2.1.1.7.03 Зочин төлөөлөгч хүлээн авах | 22,000 | 16,230.85 |
| 87 | 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,198,314.7 | 3,815,534.9 |
| 88 | 3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,081,849.6 | 3,722,217.77 |
| 89 | 3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ | 15,295.8 | 11,744.33 |
| 90 | 3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар | 10,557.1 | 6,044.42 |
| 91 | 3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо | 3,415.3 | 1,688.5 |
| 92 | 3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 53,912.5 | 47,903.2 |
| 93 | 3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр | 33,284.4 | 25,936.68 |
| 94 | 3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 14,815,789 | 13,116,030.87 |
| 95 | 3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал | 14,319,167 | 12,726,732.27 |
| 96 | 3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 496,622 | 389,298.6 |
| 97 | 3.1.01.2.1.2 ХҮҮ | 507,311.9 | 507,311.9 |
| 98 | 3.1.01.2.1.2.2 Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 507,311.9 | 507,311.9 |
| 99 | 3.1.01.2.1.2.2.01 Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 507,311.9 | 507,311.9 |
| 100 | 3.1.01.2.1.3 ТАТААС | 437,000 | 285,567.4 |

| | | | |
|---|---|---|---|
| 101 | 3.1.01.2.1.3.1 Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 12,000 | 0.0 |
| 102 | 3.1.01.2.1.3.1.01 Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 12,000 | 0.0 |
| 103 | 3.1.01.2.1.3.2 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 425,000 | 285,567.4 |
| 104 | 3.1.01.2.1.3.2.01 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 425,000 | 285,567.4 |
| 105 | 3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,917,617.8 | 2,531,213.04 |
| 106 | 3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг | 1,503,047.3 | 1,412,210.68 |
| 107 | 3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг | 1,503,047.3 | 1,412,210.68 |
| 108 | 3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | 1,414,570.5 | 1,119,002.36 |
| 109 | 3.1.01.2.1.4.2.02 Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 135,245 | 72,240 |
| 110 | 3.1.01.2.1.4.2.03 Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 212,870 | 181,318.87 |
| 111 | 3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 228,990.8 | 228,990.76 |
| 112 | 3.1.01.2.1.4.2.06 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 483,991.7 | 357,078.04 |
| 113 | 3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 154,613 | 146,273.5 |
| 114 | 3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 198,860 | 133,101.19 |
| 115 | 3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 27,570,200.3 | 20,172,011.3 |
| 116 | 3.1.01.2.2.1 Барилга байгууламж | 36,000 | 6,000 |
| 117 | 3.1.01.2.2.2 Их засвар | 669,289.8 | 644,949.8 |
| 118 | 3.1.01.2.2.3 Тоног төхөөрөмж | 13,600 | 13,600 |
| 119 | 3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө | 26,851,080 | 19,507,461.5 |
| 120 | 3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 5,169,498 | 2,458,143.15 |
| 121 | 3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл | 5,169,498 | 2,458,143.15 |
| 122 | 3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | -20,831,820.8 | -4,138,936.6 |
| 123 | 3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 20,831,820.8 | 4,138,936.6 |
| 124 | 3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 20,831,820.8 | 4,138,936.6 |
| 125 | 4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 29,798,876.53 |
| 126 | 5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 25,657,449.91 |
| 127 | 6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 1,399 | 1,345 |
| 128 | 6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО | 43 | 43 |
| 129 | 6.1.01 Төсвийн байгууллага | 43 | 43 |
| 130 | 6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО | 678 | 651 |
| 131 | 6.2.01 Удирдах ажилтан | 160 | 160 |
| 132 | 6.2.02 Гүйцэтгэх ажилтан | 339 | 315 |
| 133 | 6.2.03 Үйлчлэх ажилтан | 110 | 109 |

| | | | |
|---|---|---|---|
| 134 | 6.2.04 Гэрээт ажилтан | 69 | 67 |
| 135 | 6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 678 | 651 |
| 136 | 6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 300 | 287 |
| 137 | 6.5.02 Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 4 | 4 |
| 138 | 6.5.04 СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 5 | 5 |
| 139 | 6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 241 | 227 |
| 140 | 6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ) | 128 | 128 |

**НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

*/мянган төгрөгөөр/*

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 108,654,706.74 | 105,584,934.79 |
| 2 | 1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 61,523,962.08 | 68,118,595.29 |
| 3 | 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар | 20,401,501.13 | 22,502,211.52 |
| 4 | 1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -817,084.3 | -1,149,154.23 |
| 5 | 1.1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар | 940,070.01 | 1,938,486.51 |
| 6 | 1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 6,845,633.18 | 11,214,343.31 |
| 7 | 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 34,276,827.77 | 34,402,040.46 |
| 8 | 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 645,019.96 | 568,838.22 |
| 9 | 1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр | 2,424,536.14 | 2,042,721.62 |
| 10 | 1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 31,044,011.49 | 31,621,226.81 |
| 11 | 1.1.1.1.03.8.04 Бусад татвар | 163,260.17 | 169,253.81 |
| 12 | 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 42,787,291.32 | 37,466,339.51 |
| 13 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 18,790,712.27 | 22,666,063.66 |
| 14 | 1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого | 88,902.15 | 119,463.39 |
| 15 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | 0.0 | 3,713,095.46 |
| 16 | 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 23,907,676.9 | 10,967,717 |
| 17 | 1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,343,453.34 | 0.0 |
| 18 | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 74,956,511.8 | 84,655,421.8 |
| 19 | 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 74,956,511.8 | 84,655,421.8 |
| 20 | 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 71,366,714.68 | 81,313,971.71 |
| 21 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 21,887,367.61 | 25,580,482.43 |
| 22 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,110,706.82 | 3,550,097.42 |
| 23 | 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 19,599,562.06 | 25,619,727.93 |
| 24 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 2,756,525.42 | 2,147,211.73 |

| | | | |
|---|---|---|---|
| 25 | 1.1.1.2.01.1.05 Нормативт зардал | 281,841.99 | 436,740.68 |
| 26 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 1,366,379.34 | 2,244,352.4 |
| 27 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 558,931.99 | 554,783.66 |
| 28 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,909,094.51 | 6,091,207.43 |
| 29 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 15,896,304.95 | 15,089,368.03 |
| 30 | 1.1.1.2.01.2 ХҮҮ | 592,693.5 | 508,189.79 |
| 31 | 1.1.1.2.01.3 ТАТААС | 412,000 | 285,567.4 |
| 32 | 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,585,103.62 | 2,547,692.89 |
| 33 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 33,698,194.94 | 20,929,512.99 |
| 34 | 1.1.2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 7,688.53 | 13,586.02 |
| 35 | 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 24,838,498.58 | 20,935,521.42 |
| 36 | 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 24,838,498.58 | 20,935,521.42 |
| 37 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 24,838,498.58 | 20,935,521.42 |
| 38 | 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -24,830,810.05 | -20,921,935.39 |
| 39 | 1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 2,923,738.8 | 2,450,404.49 |
| 40 | 1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -2,923,738.8 | -2,450,404.49 |
| 41 | 1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 5,943,646.08 | -2,442,826.89 |
| 42 | 1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 26,380,280.86 | 32,323,926.94 |
| 43 | 1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 32,323,926.94 | 29,881,100.06 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган аймгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Тогтвортой, ногоон, эдийн засгийн хөгжлийн төв болж, улс орны хөгжилд тэргүүлэх алсын харааг тодорхойлж”, “Оюун мэдлэгийг дээдэлсэн, амгалан тайван, элбэг хангалуун амьдрал бүхий иргэдтэй” үйлдвэрлэл бизнест ээлтэй олон тулгуурт хөгжлийн загварыг хэрэгжүүлж цэцэглэн хөгжсөн аймаг болох эрхэм зорилгыг тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна.

- Мэдлэг боловсрол, мэдээллийн технологийн дэвшил, ногоон үйлдвэрлэлийн технологид суурилах ба уул уурхайд түшиглэсэн хөдөө аж ахуй, аялал, жуулчлал, палеонтологи, археологи, экологи, үйлдвэрлэлийн салбарыг дэмжиж эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох.
- Иргэд, хүүхэд залуust олон талт боловсролыг хүртээмжтэй олгох нөхцөл бүрдүүлэн, гэр бүл, сургуулийн орчинд зөв төлөвшил, хүмүүжил, сурах арга барил эзэмшүүлэх, соён гэгээрүүлэх замаар аль ч орны хөдөлмөрийг зах зээлд өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх.

- Төрийн үйлчилгээг харилцаа, хандлагын өндөр түвшинд хүргэж, хувь хүний халдашгүй байдал, хууль ёсны эрх ашгаа хамгаалуулах, шударгаар шийдвэрлүүлэх, авлига, хүнд сурталгүй, нээлттэй, ил тод, хүчирхийллээс ангид, айдасгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Аймгийн хүн бүрд нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт үед нь илрүүлэх, оношлох, эрүүл зөв дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх замаар дундаж наслалтыг нэмэгдүүлэх.
- Говь цөлийн бүсийн байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, хүрээлэн буй орчны унаган төрхийг хэвээр хадгалан үлдээх, хүний буруутай үйл ажиллагаа, уул уурхайн хайгуул, олборлолт, дэд бүтэц, үйлдвэрлэлээс байгальд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчны хэтийн бодлогын удирдлагыг орон нутгийн түвшинд оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх, тэдгээрт хяналт тавих.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Үүнд:

Монгол улсын хөгжлийн бодлого:
- Алсын хараа 2050
- Хөгжлийн зорилтот хөтөлбөр
- Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- Үндэсний хөтөлбөр
- Салбарт төрөөс баримтлах бодлого
- Шинэ сэргэлтийн бодлого
- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө
- Салбарын хөгжлийн үзүүлэлт

Орон нутгийн хөгжлийн бодлого:
- Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймаг, сумын хөгжлийн жилийн төлөвлөгөө
- Монгол улсын хууль, Засгийн газрын тогтоол шийдвэрүүд
- Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ
- Аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай байгуулсан гэрээ болон бусад холбогдох хууль журмыг баримтлан ажиллажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байсан.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагууд аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар батлагдсан бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байгаа ч зарим бүртгэлийг Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тогтоолтой уялдуулан шинэчлэх шаардлагатай байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,794.0 сая төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна.

*Хүснэгт №1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/сая.төг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 32,323.90 | 29,881.10 | -2,442.80 |
| Авлага | 7,973.50 | 8,277.60 | 304.10 |
| Бараа материал | 6,617.85 | 6,881.10 | 263.25 |
| Урьдчилгаа | 6.80 | 38.90 | 32.10 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 666.10 | 186.50 | -479.60 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 213.00 | 59.50 | -153.50 |
| Үндсэн хөрөнгө | 111,604.50 | 120,875.10 | 9,270.60 |
| **Нийт хөрөнгө** | **159,405.80** | **166,199.80** | **6,794.00** |
| Өр төлбөр | 22,145.40 | 23,607.30 | 1,461.90 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 137,260.40 | 142,592.50 | 5,332.10 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **159,405.80** | **166,199.80** | **6,794.00** |

*Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нийт хөрөнгө, өр төлбөр ба цэвэр хөрөнгийн данснуудын үлдэгдлүүд нэмэгджээ.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 29,881.02 сая төгрөг болж, өмнөх оноос 2,442.9 сая төгрөг буюу 8 хувиар буурсан байна.

*Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая.төг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Кассад байгаа бэлэн мөнгө | 3.7 | 1.20 | - 2.50 |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 32,320.20 | 29,879.86 | - 2,440.34 |
| Төгрөг | 32,320.20 | 29,879.86 | - 2,440.34 |
| Төрийн сангийн харилцах | 31,810.80 | 28,551.39 | - 3,259.41 |
| Арилжааны банк дахь харилцах | 509.40 | 1,328.47 | 819.07 |
| **Дүн** | **32,323.90** | **29,881.06** | **- 2,442.84** |
| *Үүнээс: Байгууллагын төрлөөр* | | | |
| ОНӨҮГ | 513.09 | 1,329.70 | 816.61 |
| Төрийн сан | 22,162.59 | 18,106.80 | - 4,055.79 |
| Төсөвт байгууллага | 9.67 | 1.90 | - 7.77 |
| Төсөл, сан | 9,638.55 | 10,442.62 | 804.07 |
| **Дүн** | **32,323.90** | **29,881.02** | **- 2,442.88** |

*Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан*

Мөнгөн хөрөнгийн данс 2,442.9 сая төгрөгөөр буурахад Төрийн сан буюу аймаг, сумын ерөнхий орлого 4,055.79 сая төгрөгөөр буурсан, төсөл сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл 804.0 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Банканд байгаа мөнгөн хөрөнгийн 28,551.39 сая төгрөг буюу 95.5 хувь буюу төрийн сангийн харилцах, 1,328.47 сая төгрөг буюу 4.5 хувь нь арилжааны банканд байршиж байна.

Төсөвт байгууллагын үлдэгдэл 1.9 сая төгрөг нь Булган сумын ахмадын сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Арилжааны банканд байршиж байгаа 1,328.47 сая төгрөг нь 100 хувь ОНӨААТҮГ, өрхийн эрүүл мэндийн төвийн үлдэгдэл байна.

*<u>Аудитын илрүүлэлт</u>*

***Мөнгөн хөрөнгөтэй холбоотой нийт 1,322.0 сая төгрөгийн 57 зөрчил илэрснээс 842.1 сая төгрөгийн 8 алдааг аудитын явцад зарлуулж 17.3 сая төгрөгийн зөрчилд 20 төлбөрийн акт, 61.2 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 401.4 сая төгрөгийн зөрчилд 23 зөвлөмж хүргүүлж ажиллалаа.***

*Тухайлбал:*

- *Арвилан хэмнэлт үр ашгийг дээшлүүлэхтэй холбоотой 0.5 сая төгрөгийн зөвлөмжийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт, Хутаг-Өндөр сумын ЗДТГ-т*
- *Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн буюу Өр авлага үүсэх 0.5, томилолтоор ажилласан 7 ажилтанд 0.01 төгрөгийн хоолны мөнгө давхардуулан олгосон, шатахууны зардал, томилолтын зардлыг анхан шатны баримтгүй олгосон зэрэг нийт 2.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон. /Бүрэгхангай сумын ЗДТГ, Гурванбулаг сумын ЗДТГ, Хутаг-Өндөр сумын ОНХС, Тэшиг-Ус" ОНӨААТҮГ/*
- *Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой буюу ОНӨГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн Б/05 тушаалаар хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтаар байгууллагын дарга өөртөө*

*тушаал гаргаж буцалтгүй тусламж авсан, тайлант онд түрээсийн орлогыг 634.3 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 439.4 сая төгрөгийн орлого орж 194.9 сая төгрөгийн төлөвлөгөө тасарсан, гадаад томилолтын анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй нотлох баримт дутуу, хоршоо хөгжүүлэх сангаас "Хөрх бүрдийн хишиг" хоршооны барьцаа хөрөнгийг үнэлсэн мэргэжлийн байгууллагын үнэлгээ хийлгээгүй, ОНХС-гаар хийгдсэн Шинэ суурьшлын бүсэд худаг гаргаж хүлээлгэн өгөх хүсэлтээ өгсөн ч ажлын хэсэг цахилгаан татсаны дараа шалгаж хүлээж аваагүй хойшлуулсан гэх мэт нийт 387.9 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн. /Бүрэгхангай сумын ЗДТГ, Гурванбулаг сумын ЗДТГ, Рашаант сумын ЗДТГ, Бүрэгхангай сумын ОНХС, Хишиг-Өндөр сумын ХХС, Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй" ОНӨХХК, Булган аймгийн ИТХ/*

- *Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн буюу БХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээний ажлыг хүлээн аваагүй санхүүжилтийг бүрэн олгосон, сахилгын шийтгэлтэй ажилтанд 1.5 сая төгрөгийн урамшуулал олгосон, буруутай этгээдээр актыг төлүүлээгүй төсвөөс төлсөн гэх мэт нийт 7.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон /Бүрэгхангай сум ЗДТГ, Рашаант сумын ЗДТГ, Бүрэгхангай сумын ОНХС, Гурванбулаг сумын ИТХ/*
- *Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал буюу ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл дутуу хүлээж аваагүй, төрийн захиргааны албан хаагчид мэргэжлийн зэргийн нэмэгдэл хэлс олгосон гэх мэт нийт 23.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн./Аймгийн ИТХ, Гурванбулаг сумын ЗДТГ/*

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 8,277.9 сая төгрөг болж, өмнөх оноос 304.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл*

*/сая.төг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчтай холбогдсон авлага | 29.53 | 13.69 | -15.84 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 1,050.33 | 1,242.35 | 192.02 |
| Татаас санхүүжилтын авлага | | 0.54 | 0.54 |
| Зээлийн хүүгийн авлага | 30.55 | 37.47 | 6.92 |
| Дансны авлага /ТӨҮГ/ | 1,185.46 | 1,784.76 | 599.3 |
| Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/ | 453.6 | 176.14 | -277.46 |
| Байгууллагаас авах авлага | 1,320.10 | 803.60 | -516.5 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 3,693.71 | 3,571.00 | -122.71 |
| Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээлийн авлага | 114.15 | 114.15 | 0 |
| Хувь хүмүүст олгосон зээлийн авлага | 77.85 | 390.93 | 313.08 |
| Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл | 18.21 | 142.95 | 124.74 |
| Дүн | 7,973.49 | 8,277.58 | 304.09 |
| *Үүнээс байгууллагаар* | | | 0 |
| ОНӨҮГ | 2,827.79 | 3,350.89 | 523.09 |

| | | | |
|---|---|---|---|
| Төрийн сан | 161.54 | 199.86 | 38.31 |
| Төсөвт байгууллага | 4,617.90 | 4,378.18 | -239.72 |
| Төсөл, сан | 366.24 | 348.65 | -17.58 |
| **Дүн** | **7,973.48** | **8,277.58** | **304.10** |

*Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт авлагын 40.4 хувь буюу 3,350.9 сая төгрөг нь ОНӨАТҮГ-т, 2.4 хувь буюу 199.9 сая төгрөг нь төрийн санд, 52.8 хувь буюу 4,378.8 сая төгрөг нь төсөвт байгууллагад, 4.2 хувь буюу 348.6 сая төгрөг нь тасад санд үлэгдэлтэй байна.

Авлагын дансанд сумдын ерөнхий орлогын дансанд бүртгэлтэй эзэн холбогдогчгүй нийт 93.6 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. /хавсралт-1/

Төрийн санд бүртгэлтэй авлагын үлдэгдлээс 127.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах шүүхийн шийдвэр гарч ШШГА-д хүргэгдсэн, Нийслэлийн ШШГА-аас Хутаг-Цахиур ХХК-ий авлага 2024 13.1 сая төгрөгөөр барагдсан байна.

*<u>Аудитын илрүүлэлт</u>*

*Авлагын данстай холбоотой нийт 893.5 сая төгрөгийн 25 алдаа, зөрчил илрүүлснээс 256.3 сая төгрөгийн 10 алдааг залруулж, 131.9 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага 505.3 сая төгрөгийн зөрчил 12 зөвлөмж хүргүүлж ажилласан. Тухайлбал:*

- *Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой буюу Ерөнхий орлогын тайланд өмнөх оны хувь хүнээс авах авлага 2.0 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, "Багийн бичил бизнес"-ийн зээлийн 17519.1, "Цэнгэл сан"-гийн зээлийн 7,426.9 нийт 24,946.0 мянган төгрөгийн авлагатай, тус авлагын үлдэгдлийг барагдуулах, бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй, Жижиг дунд үйлдвэрлэлийг дамжих сангаас зээл авсан 4 иргэний нийт 6.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг одоог хүртэл төсөвт төвлөрүүлээгүй, сангаас зээл олгох эрх зүйн акт байхгүй зэрэг 8.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн. /Бугат ЗДТГ, Баян-Агт ЗДТГ, Гурванбулаг ЗДТГ/*
- *Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчилд нийт 131.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн. /Бүрэгхангай сум ЗДТГ, Рашаант сумын ЗДТГ, "Булган мээж" ОНӨХХК/*
- *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой буюу Авлагыг үнэн зөв тайлагнасан ч аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан НБББББ-ийн 4.5-д заасны дагуу авлагыг урт болон богино хугацаагаар салгаж бүртгээгүй, ХХС-ийн авлагын эцсийн үлдэгдэл болох 86.4 сая төгрөгийн холбогдох иргэнтэй тооцоо нийлээгүй, Зээлийн хүүгийн авлагын эцсийн үлдэгдэлд нэмж хүү, алдангийн төлбөрийг нэмж тайлагнасан, авлагын эцсийн үлдэгдэл ХХААГ-ын хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэлтэй зөрүүтэй тайлагнасан гэх мэт нийт 410.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн./ Баяннуур сумын ХХС, Дашинчилэн сумын ХХС, Орхон сумын ХХС, Сайхан сумын ХХС /*
- *Орлого бүрдүүлэлттэй холбоотой буюу Хишиг-Өндөр сумын ЗДТГ-аас 2022 онд 5.0 сая төгрөгийн өвс 5 иргэнд олгосон ч одоог болтол өвсний төлбөрийг барагдуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.*
- *Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой буюу 2025 онд ХХС-гийн зээлдэгчийн тухайн жилд төлөгдөх зээл төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн, хэвийн бус зээлийг барагдуулах ажил хангалтгүй, "Хотол даян" ХХК-тай*

*11.5 сая төгрөгөөр нүүрс худалдан авах гэрээг байгуулж, төлбөрийг 100 хувь шилжүүлсэн ч нүүрс нийлээгүй, гэрээнд төлбөр төлөх хугацааг тодорхой тусгаагүй, авлага барагдуулах арга хэмжээ аваагүй 80.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн. /"Булган мээж" ОНӨХХК, Рашаант сумын ХХС, Сэлэнгэ сумын ХХС/*

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 38.99 сая төгрөг болж, өмнөх оноос 32.18 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4. Урьдчилгаа дансны үлдэгдэл* */сая.төг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал | 6.82 | 37.99 | 31.17 |
| Цалингийн урьдчилгаа | - | 1.00 | 1.00 |
| Томилолтын урьдчилгаа | 0.04 | 0 | -0.04 |
| Дүн | 6.86 | 38.99 | 32.13 |
| *Үүнээс: байгууллагын төрлөөр* | | | |
| ОНӨҮГ | 0.84 | 0 | -0.84 |
| Төсөл сан | 5.57 | 37.99 | 32.42 |
| Төсөвт байгууллага | 0.4 | 1.00 | 0.6 |
| Дүн | 6.81 | 38.99 | 32.18 |

*Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансны нийт үлдэгдлийн 97.4 хувийг Могод сумын БХС, Дашинчилэн сумын ОНХС-гийн хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнд урьдчилж төлсөн үлдэгдэл, 2.6 хувийг тохижилт үйлчилгээний ангийн цалингийн урьдчилгаа эзэлж байна.

*Аудитын илрүүлэлт:*

Аудитаар зөрчил илрээгүй.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 6,881.08 сая төгрөг болж, өмнөх оноос 263.31 сая төгрөг буюу 3.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт №5. Бараа материалын үлдэгдэл*

*/сая.төг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Түүхий эд материал** | **424.9** | **533.55** | **108.65** |
| Тусгай зориулалттай материал | 396 | 516.88 | 120.88 |
| Эм боох материал | 28.9 | 16.66 | - 12.24 |
| **Дуусаагүй үйлдвэрлэл** | **0** | **419.59** | **419.59** |
| **Бэлэн бүтээгдэхүүн** | **4.97** | **6.92** | **1.95** |
| **Хангамжийн материал** | **6,013.90** | **5,735.66** | **- 278.24** |
| Бичиг хэргийн материал | 111.8 | 102.89 | - 8.91 |
| Аж ахуйн материал | 1,871.00 | 1,343.77 | - 527.23 |
| Сэлбэг хэрэгсэл | 184.8 | 124.22 | - 60.58 |
| Түлш, шатах тослох материал | 71.8 | 61.99 | - 9.81 |
| Барилгын засварын материал | 53.3 | 53.37 | 0.07 |
| Хүнсний материал | 9.2 | 7.6 | - 1.60 |

| | | | |
|---|---|---|---|
| Бусад хангамжийн материал | 3,712.00 | 4,041.80 | 329.80 |
| **Биологийн хөрөнгө** | **8.7** | **9.56** | **0.86** |
| **Мал амьтад** | **165.3** | **175.8** | **10.50** |
| Дүн | 6,617.77 | 6,881.08 | 263.31 |
| *Үүнээс: байгууллагаар* | | | |
| ОНӨҮГ | 3,234.71 | 3,355.01 | 120.30 |
| Төсөл,сан | 64.06 | 62.69 | - 1.37 |
| Төсөвт байгууллага | 3,319.00 | 3,463.38 | 144.38 |
| Дүн | 6,617.77 | 6,881.08 | 263.31 |

*Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан*

Бараа материалын үлдэгдлийн 49 хувийг ОНӨҮГ , 1 хувийг төсөл сан, 50 хувийг төсөвт байгууллагын үлдэгдэл эзэлж байна.

Бараа материал данснаас түүхий эд материал 108.6, дуусаагүй үйлдвэрлэл данс 419.6 сая, бэлэн бүтээгдэхүүн 1.95 сая, мал амьтадын дансны үлдэгдэл 10.5 сая, биологийн хөрөнгө 0.86 сая төгрөгөөр тус тус өсөж, хангамжийн материал 278.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлтэй байна.

Бараа материалын дансны өсөлтөд хандиваар болон шилжүүлэн авсан бараа материалын дүн голчлон нөлөөлсөн байна.

*Аудитын илрүүлэлт*

*Бараа материалын данстай холбоотой нийт 1,030.3 сая төгрөгийн 22 алдаа, зөрчил илрүүлснээ 856.5 сая төгрөгийн 8 алдааг залруулж, 1.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 51.2 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 120.6 сая төгрөгийн зөрчил 10 зөвлөмж хүргүүлж ажилласан. Тухайлбал:*

- *Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн буюу жолоочийн тооцооны хуудсаар шатахуун зарцуулалтыг бодоогүй, спидометрийн заалт зөрүүтэй, хяналт, арвилан хэмнэлтгүй зарцуулсан 1.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон./Аймгийн ЗДТГ/*
- *Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой буюу сумын ЗДТГ болон ЖДҮДС-гийн санхүүгийн тайланд өвч тэжээлийн орлого, зарлагыг тус тус бүртгэж тайлагнасан, санхүүгийн тайланг үнэн зөв орлого, зарлагын бүртгэлийг бүрэн бүртгэж ажиллаагүй, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдан авах гэрээний хавсралт техникийн тодорхойлолт байхгүй, барааг хүлээн авсан актад техникийн үзүүлэлтүүд байхгүй зэрэг нийт 7.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн. /Булган аймгийн Засаг дарга, Рашаант сумын Засаг дарга/*
- *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой малын нас дэвшилтийн өсөлтийг тооцож тайлагнаагүй, үндсэн хөрөнгийн тайлангийн тавилга эд хогшлын дансанд 11 нэр төрлийн 11.6 сая төгрөгийн бараа материал бүртгэсэн, тоног төхөөрөмжийн дансанд мал угаалгын ванн 20.0 сая төгрөгийн хөрөнгийг ангилал буруу бүртгэсэн нийт 33.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. / Гурванбулаг сумын ЗДТГ, Могод сумын ЗДТГ/, Замын хуудсыг тухай бүрд нь бичдэггүй сарын сүүлд бөөнд нь нэг бичдэг, ямар ажлаар явсан нь тодорхойгүй, хугацаа нь тодорхойгүй, засвар үйлчилгээ хийсэн бараа материалыг зарлагдаагүй үлдэгдлээр тайлагнасан, Дэвшилт ХХК-иас 270 ширхэг ИТХ-ын тогтоол, 50 ширхэг тушаалын хэвлэмэл хуудас худалдан авсан болovч хэвлэмэл хуудасны тайлан хийгээгүй, бичиг хэргийн материал дансанд тамга, тэмдэг, хуулбар үнэн зэрэг тэмдэг, цоож, баримт үдэгч, ном зэрэг аж ахуйн болон үндсэн хөрөнгийн шинж чанартай, зарцуулсан материалыг зарлагадаагүй, дансны ангилал*

*зөрчиж бүртгэж, тайлагнасан, өмнөх онд гүйцэтгүүлсэн 60.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээнээс урьдчилгаа 30.0 сая төгрөгийг шилжүүлж малын угаалгын 2 банн бүрэн хүлээж аваагүй ч дуусаагүй үйлдвэрлэлд үлдэгдэлтэй, тайланд онд худалдан авсан шатаж тослох материалыг бараа материалын тайланд орлого болон зарцуулалтыг тайлагнаагүй гэх мэт нийт 111.3 сая төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн. /Гурванбулаг сумын ЗДТГ, Могод сумын ЗДТГ, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, Сэлэнгэ сумын ЗДТГ, Тэшиг сумын ИТХ, Тэшиг сумын ЗДТГ, Баяннуур сумын ОНХС, Гамшгаас хамгаалах сан/*

- *Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн буюу жилийн эцсийн тооллогын баримтын бүрдэл дутуу, туслах аж ахуй болох малыг гэрээ хийн маллуулдаг ч гэрээг дүгнээгүй, ашиг шимийн тооцоо хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг нийт 19.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн. /Баяннуур сумын ЗДТГ, Дашинчилэн сумын ЗДТГ/*

### 3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 186.48 сая төгрөг болж, өмнөх оноос 479.65 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая.төг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад | 666.13 | 186.48 | -479.65 |
| Дүн | 666.13 | 186.48 | -479.65 |
| *Үүнээс байгууллагаар:* | | | |
| ОНӨҮГ | 25.00 | 29.66 | 4.66 |
| Төсөл, сан | 85.69 | 30.00 | -55.69 |
| Төсөвт байгууллага | 555.44 | 126.82 | -428.62 |
| Дүн | 666.13 | 186.48 | -479.65 |

*Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан*

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэлд “Булган мээж” ОНӨХХК-ий 29.9, Баяннуур сумын ОНХС-гийн дутуу хэрэгжсэн төсөл арга хэмжээний 30.0 сая, Орхон сумын ЗДТГ-ын 126.8 сая төгрөгийн үлдэгдэл эзэлж байна.

Өмнөх оноос Хангал сумын ОНХС-гийн 55.67 сая, Хялганат тосгоны захирагчийн албаны 393.5 сая төгрөгийн ажлууд хийгдэж дууссанаар данс бүртгэлээс хасжээ.

*<u>Аудитын илрүүлэлт</u>*
*Аудитаар илрүүлэлт байхгүй*

### 3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 120,875.0 сая төгрөг болж, өмнөх оноос 9,270.5 сая төгрөг буюу 8.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт №7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая.төг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Биет хөрөнгө | 101,000.10 | 110,057.20 | 9,057.10 |
| Барилга, байгууламж, орон сууц | 48,297.20 | 54,369.17 | 6,071.97 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 4,575.20 | 6,808.55 | 2,233.35 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 21,351.10 | 21,315.48 | -35.62 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 2,389.90 | 2,581.20 | 191.30 |
| Зам гүүр байгууламж | 8,239.30 | 8,119.69 | -119.61 |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 956.8 | 957.77 | 0.97 |
| Бусад үндсэн хөрөнгө | 15,047.70 | 15,729.19 | 681.49 |
| Ном | 142.9 | 176.15 | 33.25 |
| Биет бус хөрөнгө | 10,604.40 | 10,817.86 | 213.46 |
| Программ хангамж | 232.6 | 441.63 | 209.03 |
| Бусад биет бус хөрөнгө | 10,371.80 | 10,376.23 | 4.43 |
| Дүн | 111,604.50 | 120,875.06 | 9,270.56 |
| *Үүнээс: байгууллагаар* | | | |
| ОНӨҮГ | 35,540.81 | 34,083.61 | -1,457.20 |
| Төсөл,сан | 4.33 | 1.17 | -3.17 |
| Төсөвт байгууллага | 76,059.40 | 86,790.28 | 10,730.88 |
| Дүн | 111,604.54 | 120,875.06 | 9,270.51 |

*Эх сурвалж:Булган аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт үндсэн хөрөнгийн 86,790.3 сая төгрөг буюу 71.8 хувийг төсөвт байгууллагад, 34,083.6 сая төгрөг буюу 28.1 хувийг ОНӨҮГ, 1.17 сая төгрөг буюу 0.1 хувийг төсөл санд бүргэлтэй байгаа бөгөөд 91.0 хувийг биет хөрөнгө, 9 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4,895.9 сая, хандиваар 2,380.1 сая, шилжүүлэн авсан 7,416.9 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 15.6 сая, бусад эх үүсвэрээс 4,852.2, дахин үнэлгээний нэмэгдэл 325.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт 1,453.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан борлуулах, актлах, шилжүүлэх шийдвэрийн дагуу хасагдсан байна.

*<u>Аудитын илрүүлэлт:</u>*

*Үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 20,905.4 сая төгрөгийн 40 алдаа, зөрчил илрүүлснээс 410.9 сая төгрөгийн 12 алдааг залруулж, 10,697.6 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 9,796.9 сая төгрөгийн зөрчилд 20 зөвлөмж хүргүүлжээ.Тухайлбал:*

- *Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой буюу үндсэн хөрөнгийн барилга байгууламжийн дансанд бүртгэсэн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй, “Бонго” маркийн авто машинд 2 дугуй худалдан авсан болович өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүй гэх мэт нийт 512.1 сая төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн. /Орхон сумын ЗДТГ, Сайхан сумын ЗДТГ, Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй" ОНӨХХК/*
- *Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй буюу үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг нийт 62 нэр төрлийн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-т ашиглагдаж байгаа ухаалаг худаг 15.0 сая,*

*цэвэрлэх байгууламж тоног төхөөрөмж 150.0 сая, халаалтын зуух тогоо 878.2 сая, уурын зуухны өргөтгөл 19.0 сая төгрөгийн хөрөнгүүд бүртгэлтэй, мөн байгууламжийг тоног төхөөрөмжөөр бүртгэж, элэгдлийн зардлыг буруу байгуулсан, үндсэн хөрөнгийн дансанд 13 нэр төрлийн 3 138 700 төгрөгийн 29 ширхэг бараа материалыг бүртгэсэн гэх мэт нийт 12,766.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн. /Могод сумын ИТХ, Хангал сумын ИТХ, Булган аймгийн Засаг даргын тамгын газар, Могод сумын ЗДТГ, Сайхан сумын ИТХ, Сайхан сумын ЗДТГ, Тэшиг сумын ЗДТГ, Хангал сумын ЗДТГ/*

- *Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй 138.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. /Дашинчилэн сумын ЗДТГ, Орхон сумын ИТХ, Сайхан сумын ИТХ, Хишиг-Өндөр сумын ЗДТГ/*
- *Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой буюу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн шийдвэрийг гаргаагүй, үндсэн хөрөнгийн дансанд анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 22 нэр төрлийн 30 ширхэг 6438.9 төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй, үндсэн хөрөнгийн дансанд цагдаа гэсэн нэртэй 2022 онд орлогод бүртгэсэн 139,9 мянган төгрөгийг хөрөнгийн элэгдэл бодоогүй, тайлант онд 6,926.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 144.7 сая төгрөгийн бараа материалын жилийн эцсийн тооллого хийгээгүй гэх мэт 7,077.3 сая төгрөгийн албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн. /Тэшиг -ус ОНӨҮГ/*

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 10,751.5 сая төгрөг болж, өмнөх оноос 1,886.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*/сая.төг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Өглөг | 8,862.51 | 10,737.69 | 1875.18 |
| Ажилчидтай холбоотой өглөг | 91.81 | 91.87 | 0.06 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 5.6 | 863.91 | 858.31 |
| Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | 0 | 0 | 0.00 |
| Зээлийн хүүгийн өглөг | 0 | 0 | 0.00 |
| Бусад өглөг | 8,765.10 | 9,781.91 | 1016.81 |
| Байгууллагад төлөх өглөг | 8,528.80 | 9,437.01 | 908.21 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 14.9 | 126.177 | 111.28 |
| Татварын өглөг /ТӨҮГ/ | 196.7 | 128.17 | -68.53 |
| НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ | 0 | 0 | 0.00 |
| Дансны өглөг /ТӨҮГ/ | 24.7 | 90.55 | 65.85 |
| Урьдчилж орсон орлого | 2.6 | 13.81 | 11.21 |
| Бусад урьдчилж орсон орлого | 2.6 | 13.81 | 11.21 |
| Дүн | 8,865.11 | 10,751.50 | 1886.39 |
| *Үүнээс байгууллагаар* | | | 0.00 |
| ОНӨҮГ | 8,415.30 | 6,442.08 | -783.46 |
| Төрийн сан | 1.70 | 1,139.80 | -1.70 |
| Төсөвт байгууллага | 448.12 | 2,396.89 | 1898.82 |
| Төсөл, сан | - | 772.73 | 772.74 |

| | | | |
|---|---|---|---|
| Дүн | 8,865.11 | 10,751.50 | 1,886.39 |

*Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт өр төлбөрийн өр төлбөрийн үлдэгдлийн 59.9 хувь буюу 6,442.0 сая төгрөг нь ОНӨҮГ-т, 22.8 хувь буюу 2,396.8 сая төгрөг нь төсөвт байгууллагад, 10.2 хувь буюу 1,139.8 сая төгрөг нь төрийн санд, 7.1 хувь буюу 77.4 сая төгрөг нь төсөл, санд үлдэгдэлтэй байна.

Насжилт 5 жилээс дээш жил болсон эзэн холбогдолгүй, хуулийн байгууллагад шилжүүлээд шийдэгдээгүй 1 төсөвт байгууллагын 165.5, гамшгаас хамгаалах сангийн 6.1, 2015 онд үүссэн Бугат сумын ОНХС-гийн 2.5, ХХС-гийн 1.2 сая төгрөгийн өглөгүүд бүрэн барагдаагүй үлдэгдэлтэй байна.

Энэ нь тухайн байгууллагын дарга, нягтлан бодогч нар солигдсонтой холбогдуулан өмнөх онуудад өглөг үүссэн шалтгааныг мэдэхгүй, ажил хүлээлцэх ажлыг хангалтгүй зохион байгуулсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр нэмэгдэхэд голчлон улсын төсвийн орлогын гүйцэтгэлээс шалтгаалан 2025 оны 10 сараас зардлын зарцуулалтын эрхийг хязгаарласнаас шалтгаалан төсөвт байгууллагад шинээр өр, төлбөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт №9 Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл* */сая.төг/*

| | | | |
|---|---|---|---|
| Урт хугацаат зээл | 13,280.26 | 12,855.83 | -424.43 |
| Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл | 13,280.16 | 12,855.70 | -424.46 |
| Нөөц /өр төлбөр/ /ТӨҮГ/ | 0.1 | 0.13 | 0.03 |
| Дүн | 13,280.26 | 12,855.83 | -424.43 |
| *Үүнээс байгууллагаар* | | | 0.00 |
| ОНӨҮГ | 150.50 | 150.50 | 0.00 |
| Төрийн сан | 13,129.76 | 12,705.33 | -424.42 |
| Төсөвт байгууллага | - | - | 0.00 |
| Төсөл, сан | - | - | 0.00 |
| Дүн | 13,280.26 | 12,855.84 | -424.42 |

*Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урт хугацаат зээлийн өр 12,855.8 сая төгрөг болж 424.4 сая төгрөгөөр буурсан нь MON1907 зээл төлөгдөж дууссан нь голчлон нөлөөлсөн байна.

Тайлант онд дамжуулан олгох зээлийн төлөлтийг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр MON2301 зээлийн эргэн төлөлтийг 148.7, MON1907 зээлийн эргэн төлөлтийг 107.7, MON3713 1,071,6 сая төгрөгөөр буюу нийт 1,328.2 сая төгрөгийн зээл төлж, жилийн эцэст MON1907 зээл бүрэн дууссан байна.

Азийн хөгжлийн банкны Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн зээл нь долларын зээл бөгөөд оны эхний ханш 3420.25 төгрөг, оны эцэст ханш 3556.66 төгрөг болж, ханшийн зөрүүгийн гарзыг 453.2 сая төгрөгөөр тооцож бүртгэсэн байна.

*<u>Аудитын илрүүлэлт:</u>*

*Өглөгийн данстай холбоотой нийт 541.7 сая төгрөгийн 17 алдаа, зөрчил илрүүлснээс 91.7 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 74.2 сая 4 албан шаардлага 376.2 сая төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж хүргүүлсэн. Тухайлбал:*

- *Булган сумын 2024-2025 оны халаалтын улирал эхэлж байгаатай холбогдуулан үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор аймгийн Засаг даргатай 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/648 дугаартай гэрээг*

*байгуулж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 500.0 сая төгрөгийн гэрээг эргэн төлөх нөхцөлтэйгөөр зээл авсан ч хуваарийн дагуу төлөлт хийгээгүй, өглөг барагдуулаагүй. /Булган мээж ОНӨХХК /*

- *Ерөнхий боловсролын сургуулийн тогтмол зардлын өглөг үүсгэсэн 41.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн. /Бугат сумын ЗДТГ, Дашинчилэн сумын ЗДТГ/*
- *Өмнөх онд аудитлагдаагүй өглөгийг жилийн эцэст хэвээр тайлагнасан. /Сайхан сумын ОНХС/*
- *Өр төлбөрийн үлдэгдлийг тооцооны үлдэгдлийн баталгаатай тулган баталгаажуулахад 3 зээлдэгчийн зөрүүтэй байна./Тэшиг сумын ХХС*
- *НӨАТ-ын өглөгийг барагдуулаагүй байна."Ингэт дөл" ОНӨААТҮГ*

### 3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 142,592.53 сая төгрөг болж, өмнөх оноос 5,332.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №10. Засгийн газрын хувь оролцоо* */сая.төг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 38,616.86 | 38,610.93 | -5.93 |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 2,562.85 | 2,568.78 | 5.93 |
| Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 0 | 0 | 0.00 |
| Хуримтлагдсан үр дүн | 85,995.71 | 91,273.11 | 5,277.40 |
| Өмнөх үеийн үр дүн | 65,837.13 | 86,872.66 | 21,035.52 |
| Тайлант үеийн үр дүн | 20,158.57 | 4,400.46 | -15,758.12 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 10,084.98 | 10,139.70 | 54.72 |
| Дүн | 137,260.40 | 142,592.53 | 5,332.12 |

*Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын оруулсан капитал буурч, хуримтлагдсан үр дүнг 5,277.4 сая, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 54.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь төрийн аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/568 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн нийт зарлагын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аймгийн ТЕЗ-ийн 2024 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн санхүү үр тайлангийн нийт зардлын 82,011.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 820.12 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 533.0 сая төгрөгөөр тогтоосон.

**4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг тухайн байгууллагад хамаарал бүхий заалтуудын хүрээнд нягтлан шалгасан.

*Хүснэгт №11 Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой илрүүлэлт*

*/сая төгрөг/*

| Төрийн хэмнэлтийн хуулийн заалт | Нийт зөрчлийн тоо | Нийт мөнгөн дүн | Албан шаардлага | | Зөвлөмж | | Төлбөрийн акт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Тоо | Мөнгөн дүн | Тоо | Мөнгөн дүн | Тоо | Мөнгөн дүн |
| ТХТХ 13.1.1. | 1 | 20.82 | | | 1 | 20.82 | | |
| ТХТХ 14.5. | 4 | 189.89 | 4 | 189.89 | | | | |
| ТХТХ 15.1.4. | 2 | 3.00 | | | | | 2 | 3.0 |
| ТХТХ 15.1.5. | 4 | 4.00 | | | | | 4 | 4.00 |
| ТХТХ 15.1.6. | 1 | 5.40 | | | | | 1 | 5.4 |
| ТХТХ 15.1.7. | 1 | 0.64 | | | | | 1 | 0.6 |
| ТХТХ 15.1.8. | 5 | 3.71 | | | | | 5 | 3.7 |
| ТХТХ 8.1. | 3 | 3.21 | | | | | 3 | 3.2 |
| Нийт дүн | 21 | 230.67 | 4 | 189.89 | 1 | 20.82 | 16 | 20.0 |

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 230.7 сая төгрөгийн зөрчил нь өмнөх оноос 39.9 хувь буюу 153.4 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

*<u>Аудитын илрүүлэлтийг байгууллагаар дурдвал:</u>*

- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчин нийт 3.21 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон. /Бүрэгхангай сумын ЗДТГ, Дашинчилэн сумын ЗДТГ, Рашаант сумын ЗДТГ/*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэсэн заалтыг зөрчин нийт 3.71 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд*

*төлбөрийн акт тогтоосон. /Рашаант сумын ЗДТГ, Гурванбулаг сумын ЗДТГ, Гурванбулаг сумын ИТХ, Баяннуур сумын ЗДТГ/*

- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэсэн заалтыг зөрчин 0.5 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон. /Баян-Агт сумын ЗДТГ/*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" гэсэн заалтыг зөрчсөн зөрчилд 5.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн /Аймгийн ЗДТГ/*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэсэн заалтыг зөрчин нийт 4.0 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон. /Дашинчилэн сумын ИТХ, Дашинчилэн сумын ЗДТГ, Сэлэнгэ сумын ЗДТГ, Хишиг-Өндөр сумын ЗДТГ/*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэсэн заалтыг зөрчин 3.0 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон./Баян-Агт сумын ЗДТГ, Бугат сумын ЗДТГ/*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.5.-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана." гэж заасныг зөрчсөн нийт 189.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн./Дашинчилэн ОНХС, Хишиг-Өндөр сум ИТХ, Дашинчилэн ЗДТГ, Хишиг-Өндөр ЗДТГ/*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1-д "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн. /Баян-Агт ЗДТГ/*

### 4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн ТЕЗ нь 2024 оны шилэн дансанд мэдээлсэн 154 мэдээллээс 11 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар

зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.5 дахь заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Аудитын илрүүлэлт:*

